



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.04.19 № 162

танай _____-ны № _____-т

**ҮАГ-ЫН ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА**

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ^{1/2} хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Д. Энхболд* Т.БАЙГАЛМАА

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 75.2 ХУВЬТАЙ
БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛС ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД:
АРА-2023/28-01-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn,
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, Ахлах аудитор Х.Алтанчимэг
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn
Аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 9921-0906 Цахим хаяг: Tzog-erdeneg@audit.gov.mn
Аудитор Н.Энхчимэг
Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3-4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ	5-6
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	6-9
АУДИТЫН ТАЙЛАН.....	9-39
БҮЛЭГ А: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 83.4 ХУВИЙГ ХУУЛЬ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	
А.1. Төсвийн хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний 12.7 хувь буюу 7 төсөл арга хэмжээг аймгийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.	
А.2. Төсвийн хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний 98.2 хувь нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслэгдээгүй байна.	
БҮЛЭГ Б: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 72.7 ХУВЬ НЬ ХУУЛЬД НИЙЦСЭН БАЙНА.	
Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	
Б.2. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 17.7 хувь нь үр дүнгүй байна.	
Б.3. Холбогдох хууль, журмын шаардлагыг хангаагүй байхад 2 төсөл, арга хэмжээнд 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.	
Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.	
Б.5. Зарим төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах үйл ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	
БҮЛЭГ В: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 69.4 ХУВЬТАЙ БАЙНА.	
В.1. <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөгөөгүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн арга хэмжээний 30.6% нь урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.</i>	
В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.	
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	40
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	41
УЛАМЖЛАХ САНАЛ	42
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	43
ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ.....	44-46



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БОАЖС	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
БШУСС	БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
БХБС	БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД
ББАОК	БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ГАГ	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЗТХС	ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
СТСХ	САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
СХАА	САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ТАХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ
ТББ	ТЕНДЕРИЙГ БАРИМТ БИЧИГ
ТБОНӨХБАҮХАТ Х	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ХАА	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ХОХБТХ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
ЭМГ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭМТ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичиг	8
2	2022 оны Төсвийн хуулиар батлагдсан ТАХ жилийн төлөвлөгөөнд тусгаагдаагүй байдал	9
3	батлагдсан зураг төсөв шаардлагатай эсэх талаар	12
4	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	16
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн задаргаа	36
6	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа	39

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжилтийн судалгаа	6
2	2022 оны хөрөнгө оруулалт “2021-2025 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй уялдсан судалгаа	8
3	2022 оны Төсвийн хуулиар батлагдсан ТАХ-ний хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн судалгаа	10
4	Төсөл арга хэмжээний ангиллын судалгаа	11
5	2022 оны Төсвийн хуулиар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт ба ТЕЗ-аас хүргүүлсэн саналын судалгаа	11
6	тендер зохион байгуулалтын судалгаа	13
7	түншлэл болон бусад шаардлагыг хангасан худалдан авах ажиллагааны судалгаа	15
8	Аймгийн хэмжээнд 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний эрх шилжсэн, шилжээгүй, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын судалгаа	18
9	2022 онд хэрэгжсэн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний судалгаа	19
10	2022 онд шинээр хэрэгжсэн их засварын ажлын судалгаа	19
11	2022 онд шинээр хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа	20
12	2022 онд хэрэгжсэн “ТЭЗҮ” төсөл арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа	21
13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийн судалгаа	22
14	ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа	23
15	Санхүүжилтийн зарцуулалтыг дэлгэрэнгүй судалгаа	24
16	Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, их засварын судалгаа	27
17	Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа	30
18	Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн судалгаа	33
19	ОНТХО-аар санхүүжүүлсэн урсгал шинжтэй зардлын судалгаа	35
20	Багцаар зарласан тендерт шалгарсан, гэрээ байгуулсан судалгаа	36
21	Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа	37



АУДИТЫН НЭР:

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

АУДИТЫН КОД: АРА-2023/28-01-ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад Архангай аймагт 2022 онд улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХОХБТХ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн сумдын ЗДТГ, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт,



тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Алтанчимэг, аудитор Г.Цог-Эрдэнэ, Н.Энхчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023.03.01-2023.04.20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад Архангай аймагт 282,047.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 ТАХ-ний 51,527.7 сая төгрөгийг 2022 онд санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1. /сая.төгрөг/

2022 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дансанд
Эрх шилжүүлсэн	38	203,575.10	24,093.20	20,129.1	1,018.0
Эрх шилжээгүй	17	78,472.10	27,434.50		
ДҮН	55	282,047.20	51,527.70	20,129.1	1,018.0

Эх сурвалж: 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт

- Төсвийн тухай хуульд заасны дагуу 9 сайдын багцаас аймгийн Засаг даргад 203,575.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 24,093.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 38 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн ба гүйцэтгэлээр 21 төсөл арга хэмжээ нь тайлант жилд, 15 төсөл арга хэмжээ 2023 онд хэрэгжих, 2 төсөл, арга хэмжээ 2024 онд хэрэгжихээр байна. Нийт 33 ТАХ-ний 20,129.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Эх сурвалж: Аймгийн засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/254 тоот албан бичиг/
- Аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй 78,472.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2022 онд санхүүжих 27,434.5 сая төгрөгийн дүнтэй 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Эрх шилжүүлээгүй ТАХ-ний санхүүжилт нь аймгийн Төрийн сангаар дамжаагүй тул санхүүжилтийн гүйцэтгэл тодорхойгүй байна. 2022 онд батлагдсан төсөл, арга хэмжээний 31 хувь нь боловсрол, 15 хувь нь соёл, 5 хувь нь хүнс, хөдөө аж ахуй, 40 хувь нь дэд бүтцийн, 5 хувь нь эрүүл мэндийн, 4 хувь нь байгаль орчны салбарт хэрэгжихээр хуваарилагдсан байна.

Тайлант жилд ОНӨГ-т шинээр 116,091.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2022 онд 14,283.6 сая төгрөгийг санхүүжүүлэх 32 ТАХ-ний тендер худалдан авалтыг зохион байгуулсан байна. / Эх сурвалж: ОНӨГ-ын 2023 оны 02 дугаар сарын 07-ны 32 тоот албан бичиг/



Он дамжсан хөрөнгө оруулалтын тухайд: Нийт ТАХ-ээс 164,063.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ нь 2012 оноос хойш он дамжин хэрэгжиж байгаагийн 36,172.1 сая төгрөгийг 2022 онд санхүүжүүлэхээр батлагджээ. Үүнээс тайлант онд эрх шилжүүлсэн 8,514.6 сая төгрөгийн 13 ТАХ-ний санхүүжилт нь аймгийн төрийн сангаар дамжжээ.

“Төсвийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14, “Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 495 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/892 дугаар захирамжаар

2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл 1,018.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар 11-н их завсрын ажлыг 1,102.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,043.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
2. Сумдын хөрөнгө оруулалтын хувьд 7 сумын ИТХ-аар 39 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталж 681.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар: Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар нийт 10,139.3 сая төгрөгийн зөрчил илэрч аймгийн Засаг даргад 3, ОНӨГ-т 1 зөвлөмж хүргүүлэн 669.2 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжлан, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ аудитаар зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг үнэлэв.



БҮЛЭГ А: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 83.4 ХУВИЙГ ХУУЛЬ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

А.1. ТӨСВИЙН ХУУЛИАР БАТЛАГДСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 12.7 ХУВЬ БУЮУ 7 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГААГҮЙ БАЙНА.

А.1.1. УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг 9 зорилго 73 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус бодлогын баримт бичиг тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дунд болон богино хугацааны баримт бичгүүд түүний уялдааг хангаж ажиллахыг Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заажээ.

Дүрслэл 1: Бодлогын баримт бичиг



Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулиар 6,152,300.0 сая төгрөгийн 1369 ТАХ-г 1,393,700.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс Архангай аймагт 282,047.2 сая төгрөгийн 55 ТАХ-ний 51,527.7 сая төгрөгийг 2022 онд санхүүжүүлэхээр баталсан бөгөөд эдгээр төсөл арга хэмжээ нь "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын бичигтэй уялдсан байна.

А.1.2 УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны "Монгол улсыг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2021-2025 онд хэрэгжүүлэх **санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн** 49,690,668.9 сая төгрөгийн 150 төсөл арга хэмжээг баталжээ.

2022 оны хөрөнгө оруулалт "2021-2025 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-тэй уялдсан судалгаа

Хүснэгт-2.

№	Бодлогын нэр	2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр		2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ		Хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаагүй ТАХ	
		тоо	Шаардагдах хөрөнгө	тоо	Шаардагдах хөрөнгө	тоо	Шаардагдах хөрөнгө
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	6	459,088.50	6	23,723.3	6	23,723.30
2	Хүний хөгжил	19	2,633,902.50	22	71,698.30	2	10,346.70



3	Амьдралын чанар ба дундаж давхарга	14	2,901,945.40				
4	Эдийн засаг	56	34,675,915.30	24	177,025.60	16	59,619.30
5	Засаглал	9	553,409.40				
6	Ногоон хөгжил	6	1,136,794.10	2	4,200.00		
7	Амар тайван, аюулгүй нийгэм	11	744,494.20	1	5,400.00	1	5,400.00
8	Бүс, орон нутгийн хөгжил	18	4,977,899.00				
9	Улаанбаатар ба дагуул хот	11	1,607,220.50				
НИЙТ ДҮН		150	49,690,668.90	55	282,047.20	25	99,089.30

Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Архангай аймагт батлагдсан 282,047.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 ТАХ-ний 182,457.9 сая төгрөгийн 30 ТАХ нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдсан /ойролцоо утгаар авсан/, 99,589.3 сая төгрөгийн 25 ТАХ нь уялдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹-т заасантай нийцэхгүй байна.

A.1.3 УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг баталсны дагуу Аймгийн ИТХ-ийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны 12 тоот тогтоолоор "Архангай аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө"-г баталсан байна. Хууль батлагдсаны дараа аймгийн ТЕЗ нь дунд болон богино хугацааны бодлогын бичгийг ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулсан боловч төсвийн хуульд тусгагдсан 6,650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусган батлуулаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.14², 5.2.3³, 5.1.12⁴ дахь заалтуудтай нийцээгүй байна.

2022 оны Төсвийн хуулиар батлагдсан ТАХ жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байдал

Дүрслэл 2.



Тухайлбал:

1. ХХААХҮС-аас эрх шилжээгүй XVII.3.5 хуулийн дугаартай 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эрүүл хүнс-малчны хотноос" төсөл,

¹ 5.1.3. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

² 4.1.14 "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

³ 5.2.3 "нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;

⁴ 5.2.12. "төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж "дээрээс доош" төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг;



2. БХБС-аас эрх шилжиж ирсэн XII.1.158 хуулийн дугаартай 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл, XII.1.149 хуулийн дугаартай 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Булган сумын халуун усны барилга,
3. БОАЖС-аас 2019 оноос эхлэн хэрэгжиж буй 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 262.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажил,
4. ЭХС-аас эрх шилжээгүй 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-г тухай бүрийн нэршлээр нь батлуулаагүй хүрэх үр дүнгийн шалгуурыг тодорхойлоогүй байна.

Аудитаас Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бодлогын баримт бичигт нэг бүрчлэн бүрэн тусгаж, суурь түвшин, хүрэх үр дүнг тайлагнаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилтыг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг бий болгож байгаа ч тайлант жилийн төлөвлөгөөгөөр 22 ТАХ- нь хүрэх түвшний зорилтот үзүүлэлтээ хангаагүй байна.

2022 оны Төсвийн хуулиар батлагдсан ТАХ-ний хүрэх үр дүнгийн судалгаа

Хүснэгт 3.

№	Хуулийн код	ТЭЗ	Эрх шилжсэн ТАХ			Эрх шилжээгүй ТАХ			Хүрэх түвшний үзүүлэлтийг хангасан эсэх	
			Тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Тийм	Үгүй
1	III	МУЕС				2	10,346.7	2,852.0	2	
2	VI	БОАЖС	2	4,200.0	462.6					2
3	X	ХЗДХС	1	5,400.0	1,290.0				1	
4	XII	БХБС	7	35,819.3	2,183.3				3	4
5	XIII	БШУС	13	30,358.6	7,112.6	4	7,400.0	3,800.0	9	8
6	XIV	СоС	5	9,741.1	1,947.4	1	13,982.2	2,475.9	3	3
7	XV	ЗТХС	6	121,356.3	11,207.3	3	15,800.0	8,670.5	7	2
8	XVII	ХХААХҮС	2	800.0	160.0	1	1,000.0	1,000.0	2	1
9	XVIII	ЭХС	2	950.0	950.0	2	800.0	400.0	3	1
10	XIX	ЭМС	1	350.0	70.0	2	23,243.0	6,446.1	2	1
11	XXIX	ЦХХХС				1	500.0	500.0	1	
Нийт дүн			39	208,975.3	25,383.2	16	73071.9	26144.5	33	22

А.2. ТӨСВИЙН ХУУЛИАР БАТЛАГДСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 98.2 ХУВЬ НЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭГДЭЭГҮЙ БАЙНА.

А.2.1. Төсвийн тухай хуулиар 11 сайдын багцаас Архангай аймагт хэрэгжүүлэхээр 282,047.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 51,527.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 55 ТАХ-г баталснаас 45 ТАХ нь барилга байгууламж, 5 ТАХ нь тоног төхөөрөмж, 2 ТАХ нь ТЭЗҮ, 3 ТАХ нь их засвар байна. Нийт ТАХ-ээс 38ТАХ-ний эрхийг шилжүүлсэн ба шинээр 29 ТАХ хэрэгжиж 26 ТАХ өмнөх оноос шилжиж ирсэн байна. Төсөл арга



хэмжээний хэрэгжих хугацааг төсвийн хуультай уялдуулахад 17 ТАХ нь 2022 онд, 38 ТАХ нь 2023-2024 онд ашиглалтад орохоор байна.

Төсөл арга хэмжээний ангиллын судалгаа

Хүснэгт 4.

Харин шинээр хэрэгжих 29 ТАХ-ээс тухайн төсөв захирагчийн өмчлөлд шилжих боломжгүй ХХААХҮС-аас эрх шилжээгүй XVII.3.5 хуулийн дугаартай 1,000.0 сая

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Тоо	Шинэ, шилжих	Эрх шилжсэн	Эрх шилжээгүй	НИЙТ ДҮН	2022		2023-2024	
							Ашиглалтад орох тоо			
1	Барилга байгууламж	45	Шилжих	12	12	24	11			34
			Шинэ	17	4	21				
2	Тоног төхөөрөмж	5	Шилжих	0	0	0				
			Шинэ	4	1	5	2	3		
3	ТЭЗҮ	2	Шилжих	2	0	2	1		1	
			Шинэ	0	0	0				
4	Их засвар	3	Шилжих	0	0	0	0			
			Шинэ	3		3	3			
НИЙТ ДҮН		55	Шилжих	14	12	26	12		35	
			Шинэ	24	5	29	5	3		

төгрөгийн өртөгтэй "Эрүүл хүнс-Малчны хотноос" төслийн хүрээнд ХХААХҮЯ-ны харьяа Малын удмын сангаас 2022 онд 10 сумын 16 мал үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшилд 430 тооны Сэлэнгэ үүлдрийн үхэр олгосон байна. Аж ахуй нэгжүүд Малын удмын сантай гэрээ байгуулан, малаа хүлээн авсан бөгөөд орон нутагт тус гэрээнд тавих хяналтгүй, бүртгэлгүй байгаа нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй хөрөнгө оруулалт байна.

A.2.2. Аймгийн ТЕЗ-аас 2021 оны 05 дугаар сарын 05-ны 01/542 тоот албан бичгээр Сангийн яам, БШУЯ, Соёлын яам, ЗТХЯ, ЗГХЭГ, БХБЯ, ХХААХҮЯ, ХНХЯ, ЭМЯ зэрэг 9 ТЕЗ-д сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам"-ын дагуу бодлогын зорилго, зорилт улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан батлагдсан зураг төсөвтэй 6, зураг төсөвгүй 34 нийт 40 саналыг хөрөнгө оруулалтын www.pimis.mn цахим системээр үнэлж хүргүүлснээс 1 ТАХ нь төсвийн тухай хуульд тусгагдсан, үлдэгдэл 39 ТАХ нь жагсаалтад тусгагдаагүй байна.

2022 оны Төсвийн хуулиар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт ба ТЕЗ-аас хүргүүлсэн саналын судалгаа

Хүснэгт 5.

№	Хуулийн код	ТЕЗ	Төсвийн хуулиар батлагдсан шинээр хэрэгжих ТАХ-ний			ТЕЗ-аас хүргүүлсэн саналын			Тайлбар
			Тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	
1	III	МУЕС				9	6,600.0	5,400.0	ТЕЗ-аас хүргүүлсэн
2	VI	БОАЖС	1	200.0	200.0				



3	X	ХЗДХС	1	5,400.0	1,290.0				саналаас 1 ТАХ-г төсвийн хуулиар төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан. Бусад арга хэмжээ дэмжигдээгүй.
4	XI	ХНХС				2	6,600.0	3,100.0	
5	XII	БХБС	3	30,400.0	1,140.0	12	51,946.0	20,216.0	
6	XIII	БШУС	9	20,804.9	3,698.0	6	7,256.0	5,256.0	
7	XIV	СоС	1	4,422.4	750.0	3	2,575.0	875.0	
8	XV	ЗТХС	5	52,356.3	5,097.6	4	12,200.0	7,500.0	
9	XVII	ХХААХҮС	3	1,800.0	1,160.0	2	4,000.0	4,000.0	
10	XVIII	ЭХС	4	1,750.0	1,350.0	1	150.0	150.0	
11	XIX	ЭМС	1	350.0	70.0	1	1,800.0	800.0	
12	XXIX	ЦХХХС	1	500.0	500.0				
НИЙТ ДҮН			29	117,983.6	15,255.6	40	93,127.0	47,297.0	

Дунд болон урт хугацааны бодлогын бичигт тусгагдсан ТАХ-ны саналыг сум, байгууллагаас авч аймгийн хэмжээнд нэгтгэн, холбогдох ТЕЗ-д албан ёсоор хүргүүлж байгаа ч ТЕЗ нар нь орон нутгаас ирүүлсэн саналыг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлэхдээ орон нутгаас эдийн засгийн үр өгөөж нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлага зэрэг судалгааг төдийлөн авахгүйгээр ямар шаардлага шалгуураар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр хүргүүлж байгаа нь орон нутагт мэдэгдэхгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой дээрх зөрчил жил бүр давтагдан гардаг бөгөөд орон нутгийн хэрэгцээ шаардлагыг ТЕЗ-д төдийлөн авч хэлэлцэхгүйгээр өөрийн эрх мэдлийн хүрээнд хөрөнгө оруулалтын жагсаалтыг төлөвлөсөөр байна.

Дүрслэл 3.

A.2.3 УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Архангай аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 117,983.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 15,255.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 29 ТАХ-ээс 2,750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ нь батлагдсан зураг төсөв шаардлагагүй, 13,525.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-нь ажлын даалгавар, зураг төсөв бусад зөвшөөрөл олгогдсон байна.

2,750.0 сая төгрөгийн
төсөвт өртөгтэй 6 ТАХ

ЗУРАГ ТӨСӨВ
ШААРДЛАГАГҮЙ

13,525.6 сая төгрөгийн
төсөвт өртөгтэй 23 ТАХ

ЗУРАГ ТӨСӨВ
ШААРДЛАГАТАЙ

Салбар яамдын ТЕЗ-гчид нь зураг төсөвгүй, ажлын даалгавар хангалтгүй, бусад зөвшөөрөл шийдэгдээгүй, аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй хөрөнгө оруулалтыг батлуулж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

1. БХБС-аас эрх шилжсэн XII.1.91 хуулийн дугаартай 30,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ТАХ нь батлагдсан зураг төсөвгүйгээр ТБОНӨХБАҮАТХ-ийн 8.10⁵-д заасны дагуу зохион байгуулсан.
2. XII.1.158 хуулийн дугаартай 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэлийн тендер худалдан авалт нь зураг төсөвгүйгээр ажлын даалгавраар зохион байгуулагдсан ч зураг төсөв, ТЭЗҮ нь Барилгын хөгжлийн төвийн 2022.09.13-ны 1684/2022 дугаар

⁵ 8.10. Зураг төсөл, барилга угсралт, тохируулгын ажлыг энэ хуулийн 5.1.16-д заасан журмаар түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер зарлаж болно



магадлалын ерөнхий дүгнэлтээр 489.6 сая төгрөгөөр баталгаажуулж төсөвт өртөг магадлалын зөрүү 189.6 сая төгрөг болж нэмэгдсэн

3. Соёлын сайдаас эрх шилжсэн XIV.1.59 хуулийн дугаартай Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилгын ажлын газрын археологийн дүгнэлт эцэслэгдэн шийдэгдээгүй байхад батлагдсан
4. БОАЖС-аас эрх шилжсэн VI.1.20 хуулийн дугаартай Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэсэн газар оновчгүй, ажлын даалгавар нэршил 2 зөрүүтэй. Нэршилдээ тохирсон ажлыг гүйцэтгээгүй.

Аудитаас батлагдсан зураг төсөвгүй, бусад зөвшөөрөл шийдэгдээгүй ТАХ-г батлаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалтыг зөрчиж байгаа төдийгүй, аймаг орон нутгийн ТЕЗ-ийн саналд үндэслэн батлуулж байх саналыг аудитын тайлангаар Үндэсний аудитын газар болон Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжилж байна.

A.2.4. Шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 29 ТАХ-ээс БШУС-аас эрх шилжүүлсэн XIII.1.1.237 хуулийн дугаартай 4,144.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6 дугаар багт баригдах 160 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын урсгал зардал орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг тооцоог хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын судалгааг гаргаагүй байна. Тус баг нь 982 хүн амтай, 1990 онд ашиглалтад орсон 100 хүүхдийн хүчин чадалтай сургууль цэцэрлэгийн цогцолбор байртай бөгөөд 2023.04 сарын байдлаар бага сургуульд 25-30 сурагч, цэцэрлэг 20-25 хүүхэд суралцдаг байна. Дээрх сургуулийн барилгыг шинээр бариулахаар орон нутгаас санал гаргаж хүргүүлээгүй урсгал зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагыг бүрэн гаргаж ирүүлээгүй, төсөвт зөвхөн нэг маягийн зургаар бага сургуулийн барилгын санхүүжилтийг төлөвлөсөн байна.

Иймд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийхдээ урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдааг хангаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон, эрэмбэлж үнэлсэн ТАХ-г хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмжийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.

A.2.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтууд 2023 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжихээр байна.

БҮЛЭГ Б: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 72.7 ХУВЬ НЬ ХУУЛЬД НИЙЦСЭН БАЙНА.

Б.1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6⁶-д заасны дагуу МУЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ны 359 тоот тушаалаар 10 ТЕЗ-ын багцаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 116,583.2 сая төгрөгийн өртөг бүхий 27 төсөл арга хэмжээний тендер зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

Хүснэгт 6.

⁶ 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна:



№	Хуулийн дугаар	ТЭЗ	Анх батлагдсан		Тодотгол		Гэрээний үнийн дүн	Тендерийн хэмнэлт
			Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг		
Төсвийн хуулиар батлагдсан ТАХ								
1	III	МУЕС	1	200.0				
2	VI	БОАЖС	1	200.0	1	200.0	198.9	1.1
3	X	ХЗДХС	1	5,400.0	1	5,400.0	5,380.5	19.5
4	XII	БХБС	3	30,400.0	3	30,400.0	27,354.3	3,045.7
5	XIII	БШУС	9	20,804.5	9	20,804.9	20,655.8	149.1
6	XIV	СоС	2	4,922.4	1	4,422.4	4,075.3	347.1
7	XV	ЗТХС	5	52,356.3	5	52,356.3	52,115.3	241.0
8	XVII	ХХААХҮС	2	800.0	2	800.0	689.0	111.0
9	XVIII	ЭХС	2	950.0	2	950.0	841.8	108.2
10	XIX	ЭМС	1	350.0	1	350.0	344.8	5.2
НИЙТ ДҮН			27	116,383.2	25	115,683.6	111,655.7	4,027.9
Сайдын багцаас эрх шилжсэн ТАХ								
1	VI	БОАЖС	3	300.00	1	100.00	63.60	36.40
2	XIV	СоС	2	208.00	2	208.00	168.00	168.00
НИЙТ ДҮН			5	508.00	3	308.00	231.60	204.40
НИЙТ ДҮН			32	116,891.20	28	115,991.60	111,887.34	4,232.3

Үүнээс тайлант жилийн 1,2-р улиралд багтаан 9 ТЕЗ-ийн 115,683.5 сая төгрөгийн 25 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, 111,655.7 сая төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгож 4,027.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгосон байна.

Харин 700,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн боловч улсын төсвийн тодотголоор хасагдан хэрэгжээгүй, БОАЖС-аас эрх шилжсэн 200,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд оролцогч байхгүйн улмаас хүчингүй болсон байна.

Тайлант жилд СоЯ болон БОАЖС-ын багцаас 308.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний эрхийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр шилжүүлснээс шалтгаалан үнэлгээний хороог 2022 оны 2-р улиралд, гэрээг 3-р улиралд тус тус байгуулж ажлын гүйцэтгэл оройтсон байна.

Үнэлгээний хороо нь нийт 28 ТАХ-ны ХАА-г зохион байгуулахдаа 22 ТАХ-г анхны тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бол 5 ТАХ-г 2 удаа, 1 ТАХ-г 7 удаа шалгаруулсан байна.

Нийт тендерт шалгарсан худалдан авах ажиллагаанаас 142,895.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 11 ТАХ-нд 7 ХХК-ийг түншлэл болон бусад шаардлагыг хангасан гэж үзэн шалгаруулсан байна. Тухайлбал:

Хүснэгт 7.

№	Гүйцэтгэгчийн		Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	
	Нэр	Регистрийн дугаар		Тоо	Мөнгөн дүн
1	Шир цохио ХХК	3003418	Малын ногоон тэжээл тариалах төсөл, тоног төхөөрөмж /Архангай/	1	44.64



			Соёлын салбарт шинээр ашиглалтад орсон болон бусад барилга байгууламжийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ - 5. Соёлын төвийн тоног төхөөрөмж /Архангай, Цэцэрлэг сум/	1	38.40
2	Саруул харгуй ХХК	3003132	Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлын 2 дугаар хэсэг, 7 км /Архангай/	1	6,215.50
3	33Б ХХК, Эвт-Уул ХХК, Саруул харгуй ХХК	5419204	Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/	1	39,452.60
4	Эвт уул ХХК	5419204	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Хангай сум/	1	2,496.10
	Эвт уул ХХК		Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м /Архангай, Тариат сум, Мөрөн баг/	1	1,597.73
5	Эсгэл ХХК	3748863	Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	1	1,977.99
	Эсгэл ХХК		Сургуулийн барилгын уурын зуух, шугам /Архангай, Цэцэрлэг сум/	1	199.95
6	Тамиртаун ХХК, Эсгэл ХХК-ны түншлэл	3748863	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/	1	1,499.86
7	Энигма констракш ХХК, Хангилцаг ХХК-ны түншлэл	5186129	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/	1	26,964.80
	Энигмаконстракш ХХК		Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	1	4,075.30

Эдгээр компаниуд нь **ТӨХ-тэд тавигдах шаардлагыг түншлэлээр хангаж байгаа ч бодит нөхцөл дээр ажиллах хүчин, хүний нөөц хомсдол, техникийн давхардлаас үүдэн гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэхгүй байх эрсдэлийг бий болгож болзошгүй байна**. Мөн тус компаниуд нь УТХО-аар эрх шилжээгүй ТАХ болон ОНХС, ОНТХО-аар гүйцэтгэж байгаа ТАХ-г давхар хэрэгжүүлж байна.

Б.1.2 ТАХ-ний тендерийн баримт бичгийг Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, үнэлгээний хорооны анхны хуралдаанаар хэлэлцэн, урилга нийтэлсэн өдөр батлуулсан байна.

Эрх шилжүүлсэн бүх тендерийн урилгыг www.tender.gov.mn цахим сайт болон өдөр тутмын Өнөөдөр сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн ба Сангийн Сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3 дугаар зүйлийн хүрээнд 100 хувь цахимаар зохион байгуулжээ.

МУЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ны 359 тоот тушаалаар эрх шилжүүлсэн ТАХ-г зохион байгуулах үнэлгээний хороог аймгийн засаг даргын захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 1,2-р сард байгуулсан байна. Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай байгаа бөгөөд тендерийн баримт бичиг боловсруулахаас шалгарах хүртэлх үе шатны ажлуудад бүрэн оролцсон



байна. Гишүүд томилогдсоны дараагаар үнэлгээний хорооны гишүүдээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, тендер нээсний дараагаар ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг тус тус гаргаж хэвшсэн байна.

Тайлант жилд зохион байгуулсан тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан эсэхийг хянахад дараах байдалтай байна.Үүнд:

1. БШУС-аас эрх шилжсэн XIII.1.1.327, XIII.1.1.328, XIII.1.1.357 хуулийн дугаартай Батцэнгэл, Хотонт, Жаргалант сумдад нэг маягийн зургаар баригдах 2,882.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн барилгын тендерийн баримт бичгийг боловсруулахдаа үнэлгээний хороод ТББ-д тавигдах санхүүгийн чадавх үзүүлэлтийг өөр, өөрөөр тусгасан байна.

2. ЗТХС-аас эрх шилжсэн XV.1.1.61 хуулийн дугаартай 39,456.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын ажлын тендерт оролцсон "Даблю Экс Пи" ХХК нь ШӨХТГ, Сангийн яаманд гомдол гаргасны дагуу тус тендерийг түр түдгэлзүүлж, тендерийн баримт бичгийг хянан үзсэн байна. ШӨХТГ-аас 2022 оны 03 дугаар сарын 30-ны 01/577 тоот албан бичгээр тендерийн баримт бичигт заасан тендерт оролцогчдын өгөгдлийн хүснэгтэд тавигдах шаардлагууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 16.1⁷, 6.1⁸-д заасантай нийцэхгүй байгаа тул тендерийн өгөгдлийн хүснэгтийн тендер шалгаруулалтын зааварчилгаанд өөрчлөлт оруулах, өрсөлдөөнийг дэмжихүйц байхаар шийдвэрлэхийг даалгасан байна. Үнэлгээний хороо тавьсан шаардлагын дагуу тендерийн баримт бичгийг ахин боловсруулж, хариуг хүргүүлсэн бөгөөд тендерийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр дахин зарлаж, 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр нээлт хийхэд 39,452.6 сая төгрөгөөр ажил гүйцэтгэхээр оролцсон "ЗЗБ" ХХК, "Эвт уул" ХХК, "Саруул харгуй" ХХК түншлэл бүхий компанийг шалгаруулсан байна.

Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж олон нийтэд мэдээлсний дараа захиалагчийн зүгээс ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах, хугацаа хоцроох, нэмэлт шаардлага хүргүүлэх г.м-ээр тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулснаар тендерт оролцогч нарт ойлголтын зөрүү гарах, материалыг дутуу бүрдүүлэх г.м алдаа гарч тендерт шалгарахгүй байх, цаашид ахин тендер зарлах байдал ажиглагдаж байна.

Б.1.3 Нийт 28 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа төсөвт өртөгт уялдуулан 85.7 хувь буюу 24 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар, 10.7 хувь буюу 3 ТАХ-г харьцуулалтын аргаар, 3.6 хувь буюу 1 ТАХ-г зөвлөх үйлчилгээний тендерээр шалгаруулсан байна.

Тайлант жилд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрт зарим оролцогчоос сангийн яаманд гомдол гаргасан байна.



⁷ 16.1. Тендерт оролцогчийн техникийн чадавхи, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараахь үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно:

⁸ 6.1. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.



Тухайлбал:

1. БШУС-аас эрх шилжүүлсэн XIII.1.1.237 хуулийн дугаартай 4,144.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6 дугаар багт баригдах 160 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын тендерт оролцсон "Ди Ти Эм И Строй" ХХК нь үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй хэмээн гомдол гаргасанд СЯ-аас үнэлгээний хорооны тендерээс татгалзсан 2 шалтгааны 1-г үндэслэлтэй 1-г үндэслэлгүй хэмээн шийдвэрлэсэн байна. Гэтэл захиалагчийн зүгээс үнэлгээний хороог шийдвэрийг ахин хянаж тус компанийг шалгаруулахыг уламжилсны үндсэн дээр "Ди Ти Эм И Строй" ХХК-г шалгаруулжээ. Дээрх "Ди Ти Эм И Строй" ХХК нь урьд жилүүдэд улс, орон нутгийн төсвөөр гүйцэтгэсэн ТАХ-г хангалтгүй гүйцэтгэдэг, хүн хүч, техникийн нөөц дутмаг байхад тус компанийг шалгаруулсан нь цаашид гүйцэтгэл хангалтгүй, ажлыг төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
2. БХБС-аас эрх шилжсэн XII.1.91 хуулийн дугаартай 30,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн тендерт 2 компани оролцож тендерт шалгараагүй "Бридж констракшн" ХХК нь сангийн яаманд үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй хэмээн гомдол гаргасан бөгөөд шийдвэрлэх явцад гомдлоо татан авч шалгарсан "Энигма" ХХК, "Хангилцаг" ХХК-ний түншлэлд гэрээ байгуулах эрх олгожээ. Тус ХАА нь батлагдсан зураг төсөвгүйгээр түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарлагдсан бөгөөд Энигма ХХК, Хангилцаг ХХК нь түншлэлээр 70,30-ийн харьцаатайгаар тендерт 26,964.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн саналаа ирүүлсэн байна. Үнэлгээний хорооны тэмдэглэл, ТББ-д тавигдах шаардлагыг тулгахад тус ХХК нь сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн ажлаа гэрээний үүргийн дагуу хүлээлгэн өгөөгүй байхад шалгаруулсан байна. Дээрх нь Энигма ХХК нь СоС-аас эрх шилжсэн XIV.1.59 хуулийн дугаартай 4,422.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган суманд баригдах Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилгын тендерт өрсөлдөгчгүйгээр шалгарсан бөгөөд тайлант жилд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж дээрх 2 ТАХ-ний нийт 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан ч 2023 оны 04 сарын байдлаар ажлаа огт эхлээгүй байгаа нь цаашид тус ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх, чанартай гүйцэтгэхэд эргэлзээтэй байна.

Аудитаас үнэлгээний хорооны гишүүдэд тендер худалдан авах ажиллагаанд оролцож буй компаниудын ижил төстэй ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийг үнэлж сонгон шалгаруулалтыг явуулах албан шаардлага хүргүүлээ.

Б.2. УЛСЫН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 17.7 ХУВЬ НЬ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

Б.2.1. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 11 барилга байгууламжийн 72.7% нь зохиогч, захиалагчийн хяналтын дор норм, дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу хугацаанд нь гүйцэтгэжээ.

Аймгийн хэмжээнд 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний эрх шилжсэн, шилжээгүй, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын судалгаа



№	Үзүүлэлт	ТАХ-ний тоо	Үүнээс		ТЭЗҮ, зураг төсөвтэй эсэх	Магадлалаар баталгаажсан эсэх	Үгүй бол шалтгаан
			Эрх шилжсэн	Эрх шилжээгүй			
1	Өмнөх оноос шилжсэн	24	12	12	24	24	-
2	2022 онд шинээр хэрэгжих	21	17	4	21	19	Бага төвөгшилтэй 2 ТАХ-ний зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй
Нийт		45	29	16	45	43	

Аймгийн Засаг даргад 2022 онд эрх шилжсэн 29, эрх шилжээгүй 16 нийт 45 барилга байгууламжийн ажлаас 43 төсөл, арга хэмжээ нь ТЭЗҮ, зураг төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлттэй, 2 төсөл арга хэмжээ нь бага төвөгшилтэй тул магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй байна.

Улсын төсвийн 2022 оны оруулалтаар өмнөх оноос шилжин ирсэн 24, 2022 онд шинээр хэрэгжих 21 нийт 45 барилга байгууламжийн төсөл, арга хэмжээнээс гэрээгээр он дамжин хэрэгжих 22 төсөл арга хэмжээ байна.

2022 онд хэрэгжсэн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний судалгаа

Хүснэгт 9.

№	Нөхцөл байдал	Эрх шилжсэн ТАХ-ний тоо	Эрх шилжээгүй ТАХ-ний тоо
1	Материалын үнийн өсөлтөөр дахин магадлалын ажил хийгдэж он дамжсан	8	4
2	Гэрээний хугацаанд хэрэгжиж барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын актаар хүлээн авсан	5	3
3	Гэрээний хугацаанд хэрэгжээгүй	2	1
4	Гэрээгээр он дамжин хэрэгжиж байгаа	14	8
Нийт		29	16

Архангай аймагт 2022 онд хэрэгжиж ашиглалтад орох 23 төсөл, арга хэмжээнээс 12 ТАХ-нд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын хүрээнд материалын үнийн өсөлтийн өөрчлөлтийн магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан материалын үнийн зөрүүг 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталж он дамжсан, байна. Харин тайлангийн хугацаанд ашиглалтанд орох 11 ТАХ-ний 8-н ТАХ-г гэрээний хугацаанд улсын комиссын актаар ашиглалтад бүрэн хүлээн авч, 3 төсөл арга хэмжээ нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах /Архангай/ VI.1.6, Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ XIV.1.3, Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м /Архангай, Тариат сум, Мөрөн баг/ XV.2.1.12 төсөл, арга хэмжээнүүд нь гүйцэтгэгчээс шалтгаалан хэрэгжээгүй он дамжжээ.

Б.2.2. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3 их засварын ажлыг ТЭЗҮ, зураг төсвийн дагуу гэрээний хугацаанд гүйцэтгэжээ.



Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ нь ТЭЗҮ, зураг төсөвтэй, үүнээс 1 ТАХ нь магадлалын ерөнхий дүгнэлттэй байна. Үлдэх 2 төсөл, арга хэмжээ нь бага болон дунд зэргийн төвөгшилтэй тул магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй байна. Тайлант онд ТЭЗҮ, зураг төсвийн дагуу гэрээний хугацаанд гүйцэтгэж их засварын ажлыг улсын комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.

Хүснэгт 10. 2022 онд шинээр хэрэгжсэн их засварын ажлын судалгаа

/сая.төг/

Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	ТЭЗҮ, зураг төсөвтэй эсэх	Магадлалаар баталгаажсан эсэх	Үгүй бол шалтгаан	Хэрэгжилтийн байдал
ХII.1.149	БХБС	Халуун усны барилга /Архангай, Булган сум/	100.00	100.00	Тийм	Үгүй	Бага зэргийн төвөгшилтэй	Улсын комиссын актаар ашиглалтанд хүлээн авсан.
ХII.1.158	БХБС	Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл /Архангай, Эрдэнэбулган сум/	300.00	300.00	Тийм	Тийм	-	Улсын комиссын актаар ашиглалтанд хүлээн авсан.
ХIII.1.3.23	БШУС	Сургуулийн барилгын уурын зуух, шугам /Архангай, Цэцэрлэг сум/	200.00	200.00	Тийм	Үгүй	Дунд зэргийн төвөгшилтэй	Улсын комиссын актаар ашиглалтанд хүлээн авсан.
Нийт			500.00	500.00				

Барилга хот байгуулалтын Сайдаас эрх шилжсэн 2022 онд шинээр хэрэгжих Архангай аймгийн Эрдэнэбулган сумын худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл хийх ажлын гүйцэтгэгч "Юу зэт Эрдэнэ" ХХК нь 295.6 сая төгрөгөөр 2022.05.01-2022.12.10-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба зураг төсөв, ТЭЗҮ нь Барилгын хөгжлийн төвийн 2022.09.13-ны 1684/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 489.6 сая төгрөгөөр баталгаажсан байна. Аймгийн ГХБХБГ-аас гүйцэтгэгч "Юу зэт Эрдэнэ" ХХК ээр магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан ТЭЗҮ, зураг төсөвт тусгагдсан зарим ажлуудыг хасаж гэрээний үнийн дүнд багтаан гүйцэтгүүлжээ.

Б.2.3. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна.

Аймгийн Засаг даргад БШУСайдаас эрх шилжүүлсэн 1, ЭМСайдаас эрх шилжүүлсэн 1, ХХААХҮС-аас эрх шилжүүлсэн 2, эрх шилжүүлээгүй 1 нийт 5 техник, тоног төхөөрөмжийг нийлүүлэхээс ХХААХҮС-ын "Эрүүл хүнс-Малчны хотноос" төсөл, БШУС-ын Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах тоног төхөөрөмж нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгджээ. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө



оруулалтаар нийлүүлэх техник, тоног төхөөрөмжийн 60 хувь нь он дамжин хэрэгжихээр батлагджээ. Үүнд: Малын ногоон тэжээл тариалах төсөл, тоног төхөөрөмж /Архангай/, Малын үүлдэр, угсааг сайжруулах төсөл /Архангай/, Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн явуулын авто машин /Архангай/ нийлүүлэх арга хэмжээнүүд нь 2023 онд санхүүжих, гэрээний хугацаа дуусаагүй он дамжин хэрэгжихээр байна.

Хүснэгт 11. 2022 онд шинээр хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа

/сая.төг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Техникийн тодорхойлолт ажлын даалгавартай эсэх	Хэрэгжилтийн байдал
XVII.3.14	Малын ногоон тэжээл тариалах төсөл, тоног төхөөрөмж /Архангай/	400.0	80.0	Тийм	Гэрээгээр он дамжсан
XVII.3.5	"Эрүүл хүнс-Малчны хотноос" төсөл /Архангай/	1,000.0	1,000.0	Тийм	Бүрэн хэрэгжсэн
XVII.3.15	Малын үүлдэр, угсааг сайжруулах төсөл /Архангай/	400.0	80.0	Тийм	Гэрээгээр он дамжсан
XIII.1.3.12	Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах тоног төхөөрөмж /Архангай/	400.0	400.0	Тийм	Бүрэн хэрэгжсэн
XIX.3.16	Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн явуулын авто машин /Архангай/	350.0	70.0	Тийм	Гэрээгээр он дамжсан
Нийт		2,550.0	1,630.0		

Аудитын баг хөдөөгийн сумдын сургууль, цэцэрлэгт хуваарилсан 25 ширхэг ухаалаг самбар, 100 ширхэг зөөврийн компьютерыг түүвэрлэн техникийн тодорхойлолттой тулгаж, ашиглалтын байдлыг газар дээр нь шалгалаа. "Эрүүл хүнс-Малчны хотноос" төслийн хүрээнд 10 сумын 16 ААН-д гэрээ байгуулан нийлүүлсэн 430 толгой үхрийг тоолж тулган баталгаажуулж фото зургаар баримтжууллаа.

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна.

Б.2.4. "ТЭЗҮ" ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт 87.3 хувьтай байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оны БХБС-аас эрх шилжүүлсэн "ТЭЗҮ" ангилалд хамаарах "Сумын төвийн дахин төлөвлөлтийн зураг төсөв /Архангай, Ихтамир сум/-ийн ажил нь зураг төсөл боловсруулах гэрээний дагуу бүрэн хэрэгжиж улсын комиссын актаар хүлээн авсан байна.

Харин Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өлзийт, Батцэнгэл, Эрдэнэмандал, Хашаат сум/-ний ажлын гүйцэтгэл 74.6 хувьтай байна. Энэ төсөл, арга хэмжээг 3 багц болгон худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ба гүйцэтгэлээр Өлзийт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /1-р багц/ -ний ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн, Батцэнгэл сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /2-р багц/-ний ажил магадлалын дүгнэлт гаргуулах шатанд, Хашаат сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /3-р багц/-ний ажил БХБЯ-нд экспертийн шатанд явагдаж байна. /аймгийн ГХБХБГ-ийн төсөл, арга хэмжээний ажлын явцын гүйцэтгэлийг үндэслэв/



Хүснэгт 12. 2022 онд хэрэгжсэн “ТЭЗҮ” төсөл арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа
/сая.төг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Зураг төсөл боловсруулах гэрээтэй эсэх	Архитектур төлөвлөлтйн даалгавартай эсэх	Хэрэгжилтийн байдал
XII.4.2	Сумын төвийн дахин төлөвлөлтийн зураг төсөв /Архангай, Ихтамир сум/	97.00	20.00	тийм	тийм	3/9/2022 ББАОКД-2022/3
XII.4.4	Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өлзийт, Батцэнгэл, Эрдэнэмандал, Хашаат сум/	400.00	134.00	тийм	тийм	Хэрэгжилт 74.6 хувийн гүйцэтгэлтэй. Өлзийт сум зураг төслөө хүлээн авсан. Харин Батцэнгэл сум зураг төсөл магадлалаар хэлэлцүүлэхээр өгсөн, Хашаат сум хот байгуулалтын газрын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдсэн ба БХБЯаманд эксперт томилох хүсэлт хүргүүлсэн байна.
Нийт		497.00	154.00			

Б.2.5. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 3 барилга, байгууламж байна.

Аймгийн Засаг даргад 2021-2022 онд эрх шилжсэн 38 төсөл, арга хэмжээнээс 2 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан тайлант онд хэрэгжээгүй орхигдсон байна. Мөн 2019 оноос эрх шилжсэн 1 ТАХ-ний санхүүжилт 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаагүй он дамжсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийн судалгаа

Хүснэгт 13

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний					Гэрээний			
		Нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгчийн нэр	Огноо	Гэрээний үнэ	Дуусах хугацаа
1		Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/	2019	2021	500.0		"Хорго групп" ХХК	2019.08.12	482.00	2021.08.02
2	V.1.4	Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах /Архангай/	2019	2022	4,000.0	262.6	Эвт Уул ХХК	8/5/2019	3,991.70	11/30/2020
3	XIII.1.1.20	120 хүүхдийн дотуур байр /Архангай, Өгийнуур сум/	2019	2023	1,500.0	700.0	"Хатант Констракшн" ХХК			



	Нийт дүн		6,000.0	962.6	-	4,473.7	-
--	----------	--	---------	-------	---	---------	---

Эдгээрийг танилцуулбал:



1. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/

Боловсрол, шинжлэх ухааны Сайдаас Архангай аймгийн Тариат сумын 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ажлын гүйцэтгэгчээр “Хорго групп” ХХК-ийг шалгаруулж 482.0 сая төгрөгөөр 2019.08.12-оос 2021.08.01-ыг хүртэл хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 2021 оны байдлаар нийт 337.4 сая төгрөг буюу 70 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Гүйцэтгэлийн байдал: 2020-2021 онд цутгасан суурийн бетоны бат бэх нь стандартад заасан

хэмжээнд хүрээгүй тул буулгуулж дахин шинээр бетон цутгуулсан, 2021-2022 онд 1-р давхрын хучилтын бетоны зузаан стандартын хэмжээнд хүрээгүй учраас хучилтыг буулгуулж хавтан тавихаар тус тус шийдвэрлэсэн байна. /аймгийн ГХБХБГ-ын төсөл, арга хэмжээний ажлын явцын гүйцэтгэлийг үндэслэв/

Аудитын дүгнэлт: Ажлын хийц, чанар хангалтгүйгээс шалтгаалан 4 дэх жилдээ хийгдэж байгаа тул гүйцэтгэгч байгууллагын гэрээг дүгнэж цуцлах арга хэмжээ авах, дутуу ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг дарга-д хүргүүлээ.

2. Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах / V.1.4/

Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын гүйцэтгэгч "Эвт уул" ХХК нь 3,991.7 сая төгрөгөөр 2019.08.05-аас 2020.11.30-ны хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулж 2021 оны байдлаар 1,708.2 сая төгрөг буюу 42.7 хувийн санхүүжилт авсан ба 2022 онд гэрээний сунгалт хийгээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй тул батлагдсан 262.6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ-ын 2022.06.28-ны өдрийн 569 дугаар албан бичгээр “Эвт-уул” ХХК-д гэрээний үүрэг хариуцлагын дагуу барилгын ажлыг дуусгаж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөхийг мэдэгдсэн хэдий ч гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх талаар арга хэмжээг аваагүй байна.





Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах / V.1.4/ /фото зураг/

Гүйцэтгэлийн байдал: 2022 оны байдлаар Отгын ариун цэврийн байгууламжийн гүйцэтгэл 80%, сувгийн ажил хийгдсэн, шувуу ажиглах цамхаг хийгдсэн, нуурыг тойрсон машин орохоос хамгаалах төмөр шон хийгджээ. */аймгийн ГХБХБГ-ын төсөл, арга хэмжээний ажлын явцын гүйцэтгэлийг үндэслэв/*

Аудитын дүгнэлт: Ажлын хийц, зураг төсөвт өөрчлөлт ороогүй харин гүйцэтгэгчээс шалтгаалан ажил удааширч он дамжсан байдалтай байгаа тул захиалагч байгууллагаас гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын дагуу ажлыг гүйцэтгүүлэх талаар хууль тогтоомжийн хүрээнд шат дараатай арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлээ.

3. Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байрны барилга

Боловсрол шинжлэх ухааны яамнаас эрх шилжээгүй 2019 оноос хэрэгжсэн Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгч "Хатант Констракшн" ХХК-д 2020 онд 800.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон, 2021 онд санхүүжилт хуваарилаагүй тул ажил хийгдээгүй, 2022 онд улсын төсөвт 700 сая төгрөг батлагдсан хэдий ч гүйцэтгэгч байгууллага ажлаа хийгээгүй тул төсөвт буцаан татжээ.



Гүйцэтгэлийн байдал: 2022 оны байдлаар барилгын 1, 2 давхрын карказ, угсралтын ажил хийгдэж дууссан боловч барилгын 1 давхрын багана, дам нуруу, хучилтын бетоны марк төслийн бат бэхийг хангаагүй байна. Гүйцэтгэгч нь хүчитгэх зураг төсвийг "Бүрэн трейд" ХХК болон зураг төсөл зохиогч байгууллагаар хийлгүүлэхээр ажиллаж байна. */аймгийн ГХБХБГ-ын төсөл, арга хэмжээний ажлын явцын гүйцэтгэлийг үндэслэв/*

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ-ын 2021.07.24-ны өдрийн 460, 2022.06.28-ны өдрийн 567 дугаар албан мэдэгдлээр 2019 оноос хэрэгжсэн барилгын ажлын явц 50 хувьтай зогссон, мэргэжлийн байгууллагын зүгээс 2021 онд газар дээр нь үзлэг шалгалт хийхэд барилгын ажил чанаргүй хийгдсэн, барилгын 1, 2 давхрын каркасны бетоны цутгалтын ажил чанаргүй болсон нь лабораторийн дээж шинжилгээгээр нотлогдсон тул өөрийн хөрөнгөөр хүчитгэх арга хэмжээ авч ажиллах талаар удаа дараа шаардаж мэдэгдсэн боловч хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын хүрээнд уг төсөл, арга хэмжээ нь материалын үнийн өсөлтийн өөрчлөлтийн магадлалын 274/2022 дугаар дүгнэлтийг гаргуулан 2023 оны улсын төсвөөс 169.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлуулсан байна.



Аудитын дүгнэлт: Барилгын ТЭЗҮ, зураг төсөвт өөрчлөлт орж байгаа тул магадлалын ерөнхий дүгнэлттэй зураг төсвийг үндэслэн гүйцэтгэгчээр гэрээний үүрэг, хариуцлагын дагуу ажлыг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах талаар ҮАГ-аар уламжлуулан БШУЯ-нд албан шаардлага хүргүүллээ.

Б.3. Холбогдох хууль, журмын шаардлагыг хангаагүй байхад 2 төсөл, арга хэмжээнд 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Б.3.1. Төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэлгүйгээр 2 төсөл, арга хэмжээнд 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 38 ТАХ-ний 2022 оны санхүүжилт 24 тэрбум 93.2 сая төгрөг хийгдэхээс аймгийн Төрийн сангийн дансаар 38 ТАХ-ний 21 тэрбум 147.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээ буюу батлагдсан санхүүжилтийн 87.8 хувийг олгосон байна.

ТАХ-ний санхүүжилтийг ТЭЗ нараар ангилсан судалгаа

Хүснэгт 14.

ТЕЗ	Эрх шилжүүлсэн		Санхүүжилт хийгдсэн		Зөрүү	
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн
СС	5	1947.4	5	1777.5	-	169.9
БШУС	13	7112.6	13	5884.1	-	1228.49
БОАЖС	2	462.6	2	461.5	-	1.1
БХБС	7	2183.3	7	2143.0	-	40.27
ЭМС	1	70.0	1	70.0	-	0
ЗТХС	6	11207.3	6	9809.2	-	1398.06
ХХААХҮС	2	160.0	2	160.0	-	0
ЭХС	2	950.0	2	841.8	-	108.24
	38	24,093.2	38	21,147.1	-	2,946.1

Санхүүжилтийн зарцуулалтын судалгаа

Хүснэгт 15.

Нийт санхүүжилт	21,147.14
Гүйцэтгэгчид олгосон	19,578.2
Зохиогчийн хяналтын зардалд	550.9
Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан	1,018.0

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 38 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлийн баталгааг үндэслэн газар дээр нь тулган шалгахад дараах 2 ТАХ нь ажлыг гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- ✓ Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн XII.1.1.55 хуулийн дугаартай 2022 онд шинээр хэрэгжих Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай / ажлын гүйцэтгэгч "Энигма констракшн" ХХК-нд 2022.06.30-нд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 840.0 сая төгрөг
- ✓ аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн XIV.1.59 хуулийн дугаартай Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын ажил төсөл арга хэмжээний гүйцэтгэгч "Энигма констракшн" ХХК-нд 2022.06.30-нд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 750.0 сая төгрөг



Энэ нь тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн тендер шалгаруулалтын зааврын 41.1-д "урьдчилгаа төлбөр олгох эсэхэд үгүй гэж заасан байхад түүнийг зөрчсөн ба тайлант онд ажил гүйцэтгээгүй байхад санхүүжилт олгосон нь ТБОНӨХБАҮХАТхуулийн 44.2, 44.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангуулан урьдчилгаа төлбөрийн баталгааны бодит ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан дараагийн санхүүжилтийн эрхийг нээх арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 397 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд 2021 онд 32 төсөл арга хэмжээний 4,158.7 сая төгрөгийг шилжүүлэн авч 2022 онд 22 ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн 3,302.0 сая төгрөгийг, техник хяналтын зардалд 207.1 сая төгрөгийг, гүйцэтгэлийн баталгааны санхүүжилтэд 109.3 сая төгрөгийг нийт 3,618.4 сая төгрөгийг зарцуулж, 856.7 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 495 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд 23 төсөл, арга хэмжээний 1,018.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Б.3.2. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулаагүй байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оны 14, 2022 онд шинээр хэрэгжүүлэх 24 нийт 38 төсөл, арга хэмжээнд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын хүрээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд 2013-2024 он хүртэл хэрэгжих 30 төсөл, арга хэмжээнд Барилгын хөгжлийн төвөөс материалын үнийн өсөлтийн өөрчлөлтийн магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргаж 2023 оны улсын төсөвт 22,877.3 сая төгрөгийн төсөв батлуулсантай холбоотойгоор 2023 онд материалын үнийн өсөлтийн нэмэлт гэрээ байгуулахаар байна.

Харин улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан үндсэн гэрээний заалттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 6,215.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл чиглэлийн А027 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх 7 км хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсгийн ажлын гүйцэтгэгч "Саруул харгуй" ХХК-тай байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн №ЗТХЯ/202212041 дугаар гэрээний 7 дахь заалтад хүчингүй болсон "Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг тусгасан.
2. Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 1,597.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тариат сумын дасгалын төмөр бетон гүүр барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Эвт уул" ХХК-тай байгуулсан 2022 оны 04 дүгээр



сарын 13-ны өдрийн №ЗТХЯ/202212050 дугаар гэрээний 7 дах заалтад хүчингүй болсон "Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг тусгасан зөрчлүүд илэрлээ.

Аудитаас Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүллээ.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.4.1. Мэргэжлийн байгууллагууд нь барилга байгууламж, их засварын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлсэн барилга байгууламж, их засварын 32 төсөл, арга хэмжээнд зөвлөх үйлчилгээ, захиалагч, зохиогчийн хяналтын гүйцэтгэлийн тайлан, явцын болон нэгдсэн дүгнэлтээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд үе шатны хяналтыг хэрэгжүүлжээ.

Барилга байгууламж, их засварын 32 ТАХ-ээс 22 нь дараа онд шилжин хэрэгжих буюу гэрээний хугацаа дуусах болоогүй байна. Үлдэгдэл 10 нь барилга байгууламж, их засварын ажлууд дуусах гэрээтэйгээс 8 нь бүрэн хэрэгжсэн, 2 нь гэрээний хугацаанд гүйцэтгээгүй он дамжсан байна.

Барилга байгууламж, их засварын 32 төсөл, арга хэмжээнд явцын хяналт тавьж ажилласан эсэхийг газар дээр нь очиж тулган шалгахад захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн, ил ба далд ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулан, захиалагчийн явцын дүгнэлтийг гарган ажиллажээ.

Гэрээний хугацаанд гүйцэтгээгүй Тариат сумын Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м ажлын гүйцэтгэгч “Эвт уул” ХХК нь барилгын материалын хомсдол, үнийн өсөлттэй холбоотой ажил удааширч он дамжжээ. /Захиалагч байгууллага: Аймгийн Засаг даргын 2023.04.18-ны өдрийн 01/643 дугаар албан бичгийг үндэслэв/

Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын гүйцэтгэгч “Эвт-уул” ХХК нь 2022 онд ажил гүйцэтгэх гэрээний сунгалт хийгээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй нь гүйцэтгэгчээс шууд шалтгаалсан байна. /Б.5.3-д дэлгэрэнгүй тусгасан/

Б.4.2. Хөрөнгө оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын албанаас улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулаагүй нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна. /эх сурвалж: аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 45 дугаар албан бичгийг үндэслэв/ Үүнээс үзэхэд хөрөнгө оруулалтын явцад тавих аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт хангалтгүй байна.



Аудитаас Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дотоод хяналт шалгалт хийх, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Б.5. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Б.5.1. *Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний 21.4 хувь нь комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна.*

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 55 төсөл, арга хэмжээнээс гэрээгээр он дамжсан 29, гэрээний хугацаанд хэрэгжээгүй 2, бүрэн хэрэгжсэн 14 ТАХ байна.

Гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж ашиглалтад хүлээлгэн өгсөн 14 төсөл, арга хэмжээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нотлох баримтыг үндэслэн газар дээр нь тулган шалгахад 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна.

Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, их засварын судалгаа

Хүснэгт 16.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хуулийн дугаар	Улсын комиссын актын дугаар, Огноо		УК-оос өгөн үүргийг хэрэгжүүлсэн эсэх
1	Хөдөөгийн алслагдсан 5 багийн төвийн 30-45 кВт - нарны цахилгаан станц /Архангай, Тариат сум, Алтаад баг, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Жаргалант сум, Хоолт баг/	XVIII.1.44	ББАОКД-2022/60	11/4/2022	Тийм
2	Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Архангай/	VI.1.20	ББАОКД-2022/63	11/11/2022	Үгүй
3	Сумын төвөөс Бор бургастын рашаан хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ажил, зураг төсөв /Архангай, Төвшрүүлэх сум/	XVIII.1.36	ББАОКД-2022/31	8/18/2022	Тийм
4	Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл /Архангай, Эрдэнэбулган сум/	XII.1.158	ББАОКД-2022/72	12/14/2022	Үгүй
5	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Архангай, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Тариат сум, Алтаад баг/	XXIX.1.1.9	ББАОКД-2022/68	12/9/2022	Тийм
6	Сумын төвийн дахин төлөвлөлтийн зураг төсөв /Архангай, Ихтамир сум/	XII.4.2	ББАОКД-2022/3	3/9/2022	Тийм
7	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Архангай, Эрдэнэмандал сум/	XII.1.54	ББАОКД-2021/47	12/29/2021	Тийм
8	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	III.1.1.34	ББАОКД-2022/64	11/18/2022	Тийм
9	Соёлын төвийн барилга /Архангай, Чулуут сум/	XIV.1.17	ББАОКД-2022/16	7/6/2022	Үгүй
10	Халуун усны барилга /Архангай, Булган сум/	XII.1.149	ББАОКД-2022/53	10/11/2022	Тийм
11	Ундны усны худаг /Архангай, Хангай, Жаргалант, Тариат, Цахир сум/	XII.1.61	2021.10.12	№01	Тийм



12	Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах тоног төхөөрөмж /Архангай/	XIII.1.3.12	БШУЯ/2022 12006	2022.07.29	Тийм
13	Сургуулийн барилгын уурын зуух, шугам /Архангай, Цэцэрлэг сум/	XIII.1.3.23	ББАОКД-2022/26	8/5/2022	Тийм
14	"Эрүүл хүнс-Малчны хотноос" төсөл /Архангай/	XVII.3.5	Ашиглалтан д хүлээн авсан.		Тийм

Улсын комиссоос үүрэг даалгаврыг дутуу болон огт хэрэгжүүлээгүй дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:



өрөөний гэрэл шатсан байдалтай байлаа.

1. Архангай аймгийн Чулуут сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч "Эсгэл" ХХК нь 2022.07.06-ны өдрийн ББАОКД-2022/16 дугаар комиссын актаар хүлээлгэн өгсөн 14 заалт үүрэг даалгавраас 1, 2 дугаар давхрын "00", дүүшний агааржуулалтыг холбох, 2 дугаар давхрын "00" өрөөний хагархай угаалтуурыг солих, Соёлын төвийн хаяг хийж өгөх, барилгын бичиг баримт, зураг төсвийг ашиглагч байгууллагад 1 хувийг хүргүүлэх зэрэг ажлууд хийгдээгүй байна. Мөн ашиглалтын явцад 4

2. Байгаль орчин аялал жуулчлалын Сайдаас 2022 онд шинээр хэрэгжсэн Архангай аймгийн Эрдэнэбулган суманд "Цөлжилтөөс хамгаалах ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэгч "Мастер эрчим" ХХК нь 2022.11.11-ны ББАОКД-2022/63 дугаар улсын комиссоос өгсөн үүрэг даалгавраас явган хүний хаалгыг мал орохгүйгээр өөрчлөх ажлыг гүйцэтгээгүй мөн ашиглалтын явцад саравчны дээвэр эвдэрч, давхарласан дээврийн цаас хууларсан, 2ш хогийн сав эвдэрсэн байдалтай байлаа.



"Цөлжилтөөс хамгаалах ногоон байгууламжийн ажлын фото зураг /2023.04.15-ны байдлаар/

3. Барилга хот байгуулалтын Сайдаас эрх шилжсэн 2022 онд шинээр хэрэгжсэн 295.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл хийх ажлын гүйцэтгэгч "Юу зэт Эрдэнэ" ХХК нь 2022.12.14-ны өдрийн ББАОКД-2022/72 дугаар улсын комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг огт хэрэгжүүлээгүй байдалтай байлаа.



Энэ нь Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.9 заалттай нийцэхгүй байна.

Аудитаас гүйцэтгэгч байгууллагаар улсын комиссоос өгсөн дутуу ажлыг бүрэн дуусгах, ашиглалтын явцад үүссэн эвдрэлийг заслуулах арга хэмжээ авч, биелэлтийг тооцож хариу ирүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.

Б.5.2. Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй, хариуцлага тооцоогүй байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 55 төсөл, арга хэмжээнээс гэрээгээр он дамжсан 29, гэрээний хугацаанд хэрэгжээгүй 2, бүрэн хэрэгжсэн 14 ТАХ байна.

Гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж ашиглалтад хүлээлгэн өгсөн 14 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж ажилласан байна. Харин гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжсан 2 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй байна. Үүнд:

1. Тариат сумын Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м ажлын гүйцэтгэгч “Эвт-уул” ХХК” нь 2022.04.13-аас 2022.12.15-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2022 онд 1,393.6 сая төгрөг буюу 87 хувийн санхүүжилт авсан ба гэрээний хугацаанд гүйцэтгээгүй он дамжжээ.
2. Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын гүйцэтгэгч “Эвт уул” ХХК нь 2019.08.05-аас 2020.11.30-ны хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны байдлаар 1,708.2 сая төгрөг буюу 42.7 хувийн санхүүжилт авсан ба 2022 онд гэрээ сунгалт хийгээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй тул батлагдсан 262.6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.6 “Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих...”, МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.6-д “Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана”, гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 46.1-д “Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутам гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Гэрээний хугацаанд гүйцэтгээгүй Тариат сумын Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м ажлын гүйцэтгэгч “Эвт-уул” ХХК-ий гэрээний үүргийн биелэлтийг тооцож дүгнэх арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.



Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын гүйцэтгэгч "Эвт уул" ХХК-д хариуцлага тооцох арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлээ.

Б.5.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6-н төсөл, арга хэмжээний 5,328.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн 11,699.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 14 ТАХ-г 2022 онд холбогдох комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа

Хүснэгт 17.

Ашиглалтанд орсон		Үүнээс							
		Шинэ барилга байгууламж		Их засвар		ТЭЗҮ		Тоног төхөөрөмж	
Нийт ТАХ	Гэрээний үнийн дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн	ТАХ	Гэрээний дүн
14	11,699.8	8	9,626.5	3	589.5	1	96.3	2	1,387.5

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 8 барилга байгууламж, 3 их засвар, 1 ТЭЗҮ, 2 тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагууд бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Харин байнгын ашиглалтад хүлээн авсан 14 төсөл, арга хэмжээнээс их засварын 1 ТАХ-г ашиглагч байгууллага бүртгэл тайланд тусгаагүй, барилга байгууламжийн 5 ТАХ-г аймгийн Орон нутгийн өмчийн газар бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Бүртгэлд тусгаагүй хөрөнгийн судалгаа

Хүснэгт 18.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хуулийн дугаар	Эрх шилжсэн эсэх	Шинэ шилжих	Гүйцэтгэчийн нэр	Гэрээний дүн	Улсын комиссын актын дугаар, Огноо		Хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал
1	Хөдөөгийн алслагдсан 5 багийн төвийн 30-45 кВт - нарны цахилгаан станц /Архангай, Тариат сум, Алтаад баг, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Жаргалант сум, Хоолт баг/	XVIII.1.4 4	Тийм	Шинэ	Жи лауэр ХХК	419.08	ББАОКД-2022/60	11/4/2022	Бүртгэлд тусгаагүй
2	Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Архангай/	VI.1.20	Тийм	Шинэ	Мастер эрчим ХХК	198.90	ББАОКД-2022/63	11/11/2022	Бүртгэлд тусгаагүй
3	Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл /Архангай, Эрдэнэбулган сум/	XII.1.15 8	Тийм	Шинэ	Юу зэт эрдэнэ ХХК	295.17	ББАОКД-2022/72	12/14/2022	Бүртгэлд тусгаагүй
4	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Архангай, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Тариат сум, Алтаад баг/	XXIX.1.1 .9	Үгүй	Шинэ	Цагаан сүмбэр ХХК	490.21	ББАОКД-2022/68	12/9/2022	Бүртгэлд тусгаагүй
5	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	III.1.1.34	Үгүй	Шилжих	ЭБО СЕРВИС ХХК	2,446.70	ББАОКД-2022/64	11/18/2022	Бүртгэлд тусгаагүй



6	Соёлын төвийн барилга /Архангай, Чулуут сум/	XIV.1.17	Тийм	Шилж их	Эсгэл ХХК	1,478.28	ББАОКД- 2022/16	7/6/2022	Бүртгэлд тусгаагүй
						5,328.33			

Аудитаас улсын комиссын актаар хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй барилга байгууламжийн 5, их засварын 1 нийт 5328.3 сая төгрөгийн 6 ТАХ-ний хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах, барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэх талаар холбогдох ТЕЗ-д хандаж ТӨБЗГ-ын тогтоол гаргуулах арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлээ.



БҮЛЭГ В: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 69.4 ХУВЬТАЙ БАЙНА.

В.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ 30.6% НЬ УРСГАЛ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.

В.1.1. Аймгийн орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 1,232.7 сая төгрөгийн 11 ТАХ нь Архангай аймгийн ИТХ-ийн 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор "Архангай аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийг баталсан бөгөөд орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн Монгол улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18⁹-т заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ерөнхий нэршлээр нь баталсан нь бодлогын баримт бичигтэй уялджээ.

Харин ОНТХО-ыг хэрэгжүүлсэн 7 сумдын тухайд 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь "Сумдын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл", "Сумын 2022 оны жилийн төлөвлөгөө"-тэй уялдсан байна.

В.1.2. Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,232.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг нийт дүнгээр нь буюу "Их завсар" гэсэн нэр томъёогоор баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹⁰-т заасантай нийцээгүй байна. "Орон нутгийн 2022 оны төсөв тодотгон батлах тухай" аймгийн ИТХ-ийн 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар 1,232.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг сургууль, цэцэрлэг, ЭМТ-ийн нийт 11 байгууллагын их засварт зарцуулахаар баталжээ.

Харин ОНТХО-г хэрэгжүүлсэн 7 сумдын тухайд 681.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ-г сумын ИТХ-ын тогтоолоор нэр, байршил, төсөвт өртөг бүрээр жагсаалт гаргаж баталсан байна.

Дээрх аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлэх нийт 1,803.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 төсөл арга хэмжээний 227.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ нь урсгал шинжтэй зардал байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-¹¹ дэх заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн зарим заалттай нийцээгүй байна.

⁹ Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар

¹⁰ Санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана



ОНХТО-аар санхүүжүүлсэн урсгал шинжтэй зардлын судалгаа

№	Сумын нэр	Тоо	Төсөл арга хэмжээний нэр	Хүснэгт 19.
				Батлагдсан төсөв
1	Аймаг	2	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүлээлгийн танхим, Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн өрхийн эрүүл мэндийн төвийн засвар	33.00
		2	Эрдэнэбулган сумын Ахмадын өргөө, Архивын өрөөний засвар	37.70
2	Хашаат сум	1	Малжуулах төсөл	50.00
		1	Авто машины засвар	5.00
		1	Мод тарих хашаажуулах	24.50
3	Цэцэрлэг сум	1	Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	9.10
		1	Ахмадын хорооны дэмжлэг	1.50
		1	Хамтарсан багт дэмжлэг	1.00
		1	Хогийн цэгийн манаачийн ажлын хөлс	2.00
4	Цэнхэр сум	1	Оюунлаг цэнхэр хөтөлбөр	10.00
		1	Цахим шилжилт хөтөлбөр	7.00
		1	Гамшгаас хамгаалах	30.00
5	Жаргалант	1	Ойн хортон шавжтай тэмцэх үйл ажиллагааны зардалд 16.8 сая төгрөгөөр	16.80
Дүн		15		227.60

Төсвийн ерөнхийлөн захирагч болон сумдын засаг дарга нарт Төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй урсгал шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга хүргүүллээ.

В.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

В.2.1. Тайлант онд аймгийн ОНӨГ-аар дамжуулан зохион байгуулсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа нь 2 удаа нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдсан бөгөөд 1,232.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 1,102.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 багцад 1,202.7 сая төгрөгөөр 9 компани шалгарч 31.0 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болгон ажилласан байна.

Багцаар зарласан тендерт шалгарсан, гэрээ байгуулсан судалгаа

Багцын дугаар	ТЕЗ	ТАХ-ний нэр	Төсөв			Гэрээний үнийн дүн	Тендерийн хэмнэлт
			Тоо	Нийт төсөв	2022 онд санхүүжүүлэх		
1-р багц	Маргад оюу ХХК	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүлээлгийн танхимын засвар	1	19.0	19.0	32.00	1.0
		Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн өрхийн эрүүл мэндийн төвийн засвар	1	14.0	14.0		
2-р багц	Евро ази ХХК	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Өгийнуур сум/	1	397.0	397.0	395.8	1.2
3-р багц	Идум ХХК	Соёлын төвийн их засвар /Тариат сум/	1	250.0	150.0	239.3	10.7
4-р багц	Оюут билгүүн ХХК	Ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засвар /Төвшрүүлэх сум/	1	97.0	97.0	89.8	7.2
5-р багц	Газрын гагнаас ХХК	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Батцэнгэл сум/	1	99.0	99.0	97.5	1.5



6-р багц	Цагаан сүмбэр ХХК	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Хотонт сум/	1	86.0	86.0	85.9	0.1
7-р багц	Мандаа чулуу ХХК	Ахмадын өргөөний гадна пасадны засвар /Эрдэнэбулган сум/	1	10.0	10.00	34.40	3.3
		Архивын өрөөний засвар	1	27.7	27.70		
8-р багц	Батзүрх ХХК	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны дээврийн засвар /Хайрхан сум/	1	103.0	103.0	99.0	4.0
9-р багц	Сайхан тэрх ХХК	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Хашаат сум/	1	130.0	100.0	128.0	2.0
НИЙТ ДҮН			11	1,232.7	1,102.7	1,202.7	31.0

ТАХ-ний тендерийн баримт бичгийг Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, үнэлгээний хорооны анхны хуралдаанаар хэлэлцэн, тендерийн урилгыг www.tender.gov.mn цахим сайт болон өдөр тутмын Өнөөдөр сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн ба Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 100 хувь цахимаар зохион байгуулж оролцогчдыг нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажиллажээ.

Харин Жаргалант, Цэцэрлэг, Хотонт, Өндөр-Улаан сумд 303.2 сая төгрөгийн 28 ТАХ-ны шууд худалдан авалтыг хийсэн байна. Суманд ТАХ-г хэт жижиглэж, урсгал шинжтэй ТАХ-г хэрэгжүүлснээс шалтгаалан шууд худалдан авалт хийхэд хүргэсэн байна.

В.2.2. Тайлант жилд нийт 1,725.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 49 ТАХ хэрэгжсэн бүрэн хэрэгжсэн байна.

Аудитаар Жаргалант, Хашаат, Хотонт, Тариат, Өгийнуур, Цэнхэр, Өндөр-улаан зэрэг ОНТХО-ыг хэрэгжүүлсэн 7 сумдад ажиллаж, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг бодит байдал дээр нь ГХБХБГ-ын хяналтын инженерийн хамт шалгахад аймгийн ОНХТО-аар хэрэгжүүлсэн ТАХ-нд ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлсэн тул гүйцэтгэл болон ашиглалтын байдал хэвийн байна.

Дүрслэл 5.

Аймгийн түхайд: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн их засварын ажлын 1,043.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 11 ТАХ нь тайлант жилд бүрэн хэрэгжсэн бөгөөд зураг төсөв, ажлын даалгавартай тул захиалагч байгууллагыг төлөөлж аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалт хэвийн байна.



Сумдын түхайд: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 суманд 681.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл арга хэмжээ хэрэгжсэний 69.9 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь барилга байгууламж, хөшөө, дурсгал, 270.7 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ нь их засвар, 206.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээ нь тоног



төхөөрөмж, 134.4 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ нь урсгал зардалд тус тус зарцуулагдсан байна.

В.2.3. Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 11 ТАХ-ний 1043.5 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу гүйцэтгэгчид олгож, 39.5 сая төгрөгийг чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа

Хүснэгт 21.

№	төсөл арга хэмжээ	Тодотгосон 2022.06.06- ны 11 тогтоол	2022 онд санхүүжүүлэх дүн	Гэрээний			Олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дүн
				Огноо	Гүйцэтгэгч	дүн		
1	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүлээлгийн танхимын засвар	19.0	19.0	2022.04.29	Маргад оюу бюлдинг ххк	32.4	32.0	0.4
2	Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн өрхийн эрүүл мэндийн төвийн засвар	14.0	14.0					
3	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Өгийнуур сум/	397.0	397.0	2022.04.29	Евро ази зам ххк	395.9	370.1	26.5
4	Ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засвар /Төвшрүүлэх сум/	97.0	97.0	2022.04.29	Оюут билгүүн ххк	89.8	87.4	1.6
5	Соёлын төвийн их засвар /Тариат сум/	250.0	150.0	2022.04.29	Идум ххк	239.3	146.3	3.7
6	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Батцэнгэл сум/	99.0	99.0	2022.04.29	газрын ганаас ххк	97.5	95.1	2.4
7	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Хотонт сум/	86.0	86.0	2022.04.29	Цагаан сүмбэр ххк	85.9	83.7	2.2
8	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны дээврийн засвар /Хайрхан сум/	103.0	103.0	2022.04.29	Батзүрх ххк	99.0	97.2	1.8
9	Ахмадын өргөөний гадна пасадны засвар /Эрдэнэбулган сум/	10.0	10.0	2022.06.09	Мандаа чулуу ххк	34.4	33.5	0.9
10	Архивын өрөөний засвар	27.7	27.7	2022.04.29	Сайхан тамир ххк	128.0	98.1	
11	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Хашаат сум/	130.0	100.0					
Нийт дүн		1,232.7	1,102.7			1,202.7	1,043.5	39.5

Сумдын хувьд томоохон хэмжээний төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12.4¹²-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

- Жаргалант суманд хэрэгжүүлсэн 45.0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй гал унтраах тоноглолтой автомашин, 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худгийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийг хүлээн аваагүй байхад санхүүжилтийг 50% олгосон,

¹² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн санхүүжилтээр санхүүжих төслийн урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна



- Цэнхэр суманд хэрэгжүүлсэн 29.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын төвийн гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэлээр олгоогүй
- Цэцэрлэг суманд хэрэгжүүлсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засаг даргын тамгын газрын автомашины гарш засварын ажлын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоогүй байна.

Аудитаас ОНТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн ажлын гүйцэтгэлд үндэслэн олгож байх албан шаардлагыг Жаргалант, Цэнхэр, Цэцэрлэг сумын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.

В.2.4. Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн 1,202.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 их засварын ажлыг Барилгын тухай хуулийн 37 зүйл, Барилгын ажлын захиалагчийн дүрэмд заасны дагуу ажлын үе шат бүрд ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл үр дүнтэй байна.

Харин сумдын ОНТХО-аар хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас хяналт тавиагүй, захиалагч байгууллага өөрөө хяналтыг хэрэгжүүлдэг ч үр дүн муутай байна.


Цэцэрлэг, Жаргалант сумдын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 95.9 сая төгрөгийн 6 ТАХ-д үе шатны хяналтыг огт хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.30-д "төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ...үлдсэн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана" мөн журмын 5 дугаар зүйлийн 5.2.2-т "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ...арга хэмжээг тухай бүр авч ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаас ажлын гүйцэтгэлийн хуваарь гаргаж, үе шатны хяналт хэрэгжүүлж байх албан шаардлагыг Цэнхэр, Жаргалант сумдын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.

Дүрслэл 6

В.2.5. Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн 1,202.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 их засварын ажлыг барилга байгууламж ашиглалтад оруулах ажлын комиссын дүгнэлтээр хүлээн авснаас **ашиглагч байгууллага** 160.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй байна. Мөн сумдын ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-г төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар ажил хүлээлцэх комисс томилж хүлээн авсан байна.

Батцэнгэл сум	
Ерөнхий сургуулийн засвар	боловсролын спорт заалны их засвар
Хашаат сум	
Цэцэрлэгт хүрээлэн, Уурын зуухны засвар	Соёлын төсвийн тохижилт, худаг засвар
Аймаг	
ГБХЗХГ, 4 багийн ЭМТ, Ахмадын өргөө, Архивын өрөөны засвар	



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 онд хэрэгжүүлсэн 15 ТАХ -ний 215.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан тул хөрөнгийн бүртгэлд тусгах боломжгүй



байна. Иймд хөрөнгө оруулалтын жагсаалтад урсгал зардлыг төлөвлөж, батлахгүй байх зөвлөмжийг сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт хүргүүллээ.

Аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгах албан шаардлагын аймгийн ТЕЗ, ОНӨГ болон Хашаат, Батцэнгэл сумын засаг даргад хүргүүллээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

БҮЛЭГ А: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 83.4 ХУВИЙГ ХУУЛЬ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

А.1. Төсвийн хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний 12.7 хувь буюу 7 төсөл арга хэмжээг аймгийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

А.2. Төсвийн хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний 98.2 хувь нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслэгдээгүй байна.

БҮЛЭГ Б: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 72.7 ХУВЬ НЬ ХУУЛЬД НИЙЦСЭН БАЙНА.

Б.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Б.2. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 17.7 хувь нь үр дүнгүй байна.

Б.3. Холбогдох хууль, журмын шаардлагыг хангаагүй байхад 2 төсөл, арга хэмжээнд 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.5. Зарим төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах үйл ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

БҮЛЭГ В: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ 69.4 ХУВЬТАЙ БАЙНА.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөгөөгүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн арга хэмжээний 30.6% нь урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 75.2 ХУВЬТАЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт **16,971.3 сая төгрөгийн** зөрчил илэрснээс 7,399.3 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 9,572.0 сая төгрөгийн зөрчилд 6 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ. Мөн аудитын тайлангаар Үндэсний аудитын газарт 2 заалт бүхий уламжлах саналыг хүргүүллээ.

-----oOo-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

1. Монгол улсын Төсвийн тухай хуулиар батлагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аймгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, хүрэх үр дүнг тайлагнаж ажиллах
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийхдээ урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдааг хангаж, үндэслэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон, эрэмбэлж үнэлсэн төсөл, арга хэмжээг тусгахад анхаарч ажиллах
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй урсгал шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлэхгүй байх

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргад

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг тодорхой тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах

Аймгийн ОНӨГ-ын дарга Х.Ганхуягт

Улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан их засварын 2 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах, 5-н барилга байгууламжийн 5,328.3 сая төгрөгийн ажлуудыг орон нутгийн өмчийн бүртгэлд тусгах арга хэмжээ авах

Сумдын Засаг дарга нарт

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй урсгал шинжтэй төсөл арга хэмжээнд төлөвлөж санхүүжүүлэхгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



УЛАМЖЛАХ САНАЛ:

Аудитын явцад ажиглагдсан зүйл, аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Үүнд:

1. Боловсрол шинжлэх ухааны яамнаас эрх шилжээгүй 2019 оноос хэрэгжсэн Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгч "Хатант Констракшн" ХХК нь орон нутагт захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ-ын 2021.07.24-ны өдрийн 460, 2022.06.28-ны өдрийн 567 дугаар албан мэдэгдлээр 2019 оноос хэрэгжсэн барилгын ажлын явц 50 хувьтай зогссон, мэргэжлийн байгууллагын зүгээс 2021 онд газар дээр нь үзлэг шалгалт хийхэд барилгын ажил чанаргүй хийгдсэн, барилгын 1, 2 давхрын каркасны бетоны цутгалтын ажил чанаргүй болсон нь лабораторийн дээж шинжилгээгээр нотлогдсон тул өөрийн хөрөнгөөр хүчитгэх арга хэмжээ авч ажиллах талаар удаа дараа шаардаж мэдэгдсэн боловч 2023 оны 04 дүгээр сарын байдлаар ажлыг гүйцэтгээгүй байна. */Б.2.5 дэлгэрэнгүй тусгасан тул танилцана уу/*

Иймд Тус барилгын ТЭЗҮ, зураг төсөвт өөрчлөлт орж байгаа тул магадлалын ерөнхий дүгнэлттэй зураг төсвийг үндэслэн гүйцэтгэгчээр гэрээний үүрэг, хариуцлагын дагуу ажлыг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах албан шаардлагыг БШУЯ-нд хүргүүлэх саналыг уламжилж байна.

2. Салбар яамдын ТЕЗ-д нь зураг төсөвгүй, ажлын даалгавар хангалтгүй, бусад зөвшөөрөл шийдэгдээгүй, аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй хөрөнгө оруулалтыг батлуулж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчиж байна.

Иймд батлагдсан зураг төсөвгүй, бусад зөвшөөрөл шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг төсвийн хуулиар батлуулахгүй байх саналыг аудитын тайлангаар Үндэсний аудитын газар болон Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжилж байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлтэй танилцаад саналгүй гэсэн хариу албан бичгийг ирүүлсэн.



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: arkhangai.gov@gmail.com,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2023 04.19 № 03/664

танай _____-ны № _____-т

「 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Улс орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх тайлантай холбоотой санал, тайлбар байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АЛТАНГЭРЭЛ

Магдатор Х. Агваагийн
Танхимжав 19/12

8513980602



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 01/21

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын тавдугаар хавсралтын 1.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газраас нэгдсэн удирдамжийн дагуу "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт, хураангуй тайланг Жаргалант, Цэнхэр, Цэцэрлэг, Хашаат сумын засаг даргад хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор (Х.Алтанчимэг)-даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



"Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: АРА-2023/28-01-ШТА-ГА

№	Утга	Хүргүүлсэн шийдвэрийн			Хэрэгжилтийг хариуцах	
		Мөнгөн дүн	Тоо	Шийдвэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	2022 оны Төсвийн тухай хуулиар Архангай аймагт шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ХХААХҮС-аас эрх шилжээгүй XVII.3.5 хуулийн дугаартай 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эрүүл хүнс-малчны хотноос" төсөл, БХБС-аас эрх шилжиж ирсэн XII.1.158 хуулийн дугаартай 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл, XII.1.149 хуулийн дугаартай 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Халуун усны барилга, БОАЖС-аас 2019 оноос эхлэн хэрэгжиж буй 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 262.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажил, ЭХС-аас эрх шилжээгүй 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-г тухай бүрийн нэршилээр нь жилийн төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй нь ХБТҮТХ-ийн 4.1.14., 5.2.3, 5.1.12 дахь заалтуудтай нийцээгүй байна.		1	Зөвлөмж	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
2	БШУС-аас эрх шилжүүлсэн XIII.1.1.237 хуулийн дугаартай 4,144.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6 дугаар багт баригдах 160 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын урсгал зардал орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг тооцрог хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын судалгааг гаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.2-т заасантай нийцээгүй.	4,144.70	1	Зөвлөмж	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
3	Шинээр хэрэгжих 6,215.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл чиглэлийн А027 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх 7 км хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсгийн ажлын гүйцэтгэгч "Саруулхаргуй" ХХК, 1,597.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тариат сумын дасгалын төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Эвт уул" ХХК-тай байгуулсан гэрээнд хүчингүй болсон "Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг тусгасан зөрчил илэрлээ		1	Зөвлөмж	Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	
4	Аймгийн ОНТХО-аар 2022 онд 33.0 сая төгрөгөөр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүлээлгийн танхимын засвар, 4 дүгээр багийн өрхийн эмнэлгийн засвар, 37.8 сая төгрөгөөр Ахмадын өргөөний гадна пасады засвар, архивын өрөөний засварын ажлууд зэрэг урсгал зардлыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-тай нийцээгүй байна.		1	Зөвлөмж	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
6	Тайлант онд байнгын ашиглалтанд хүлээн авсан 14 ТАХ-нээс их засварын 2 ТАХ-г ашиглагч байгууллага бүртгэл тайланд тусгаагүй, барилга байгууламжийн 5 ТАХ-г аймгийн ОНӨГ бүртгэл тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2-т заасантай нийцээгүй байна.	5,427.33	1	Зөвлөмж	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
5	Сумдын ОНТХО-аар ойн хортон шавьжтай тэмцэх, ГХУСАЗСЗардал, сумын ахмадын хороо, сумын хамтарсан багт дэмжлэг, хогийн цэгийн манаачийн хөлс, малжуулах төсөл, мод тарих, машины засвар г.м урсгал зардлыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-тай нийцээгүй байна.		1	Зөвлөмж	Цэнхэр сумын засаг дарга	Д.Галхүү
					Жаргалант сумын засаг дарга	П.Алтанхуяг
					Хашаат сумын засаг дарга	Д.Дондов
					Цэцэрлэг сумын засаг дарга	П.Мөнхбат
6	Худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороонд ажилласан гишүүд нь тендерт тавих шаардлагыг шаардлагыг бүрэн хангаагүй гэрээний үүргийн дагуу ажлаа хүлээлгэн өгдөггүй, ажиллах хүчин, хүний нөөц хомсдол, техникийн давхардал, гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэхгүй байх эрсдлийг харгалзахгүйгээр Ди Ти Эм И Строй ХХК, Энигма ХХК, Эвт уул ХХК, Саруул харгуй ХХК зэрэг компаниудыг тендерт шалгаруулж ТБОНӨХБАЯТХ-ийн 27, 28 дугаар зүйл заалтуудыг зөрчсөн.		1	Албан шаардлага	Аймгийн ОНӨГ-ын дарга	Х.Ганхуяг
7	Энигма ХХК нь СоС-аас эрх шилжсэн XIV.1.59 хуулийн дугаартай 4422.4 төсөвт өртөгтэй Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилгын тендер, 30,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн тендер ХАА-д шалгарсан бөгөөд тайлант жилд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж шалгарсан тус 2 ТАХ-ний нийт 1,590.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан ч 2023 оны 04 сарын байдлаар ажлаа огт эхлээгүй, цаашид тус ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх, чанартай гүйцэтгэхэд эргэлзээтэй байгаа нь ТБОНӨХБАЯТХ-ийн 27, 28, 41.6 дугаар зүйл заалтуудтай нийцээгүй байна.	1,590.00	1	Албан шаардлага	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид



8	Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оны шилжих 14, 2022 онд шинээр хэрэгжүүлэх 24 нийт 38 төсөл, арга хэмжээнд 20,129.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон ба төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод аудит хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалттай нийцэхгүй байна.		1	Албан шаардлага	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
9	Чулуут сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч "Эсгэл" ХХК, Цөлжилтөөс хамгаалах ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэгч Мастер эрчим ХХК, худалдааны гудамжны инженерийн байгууламжийн засвар, шинэчлэл хийх ажлын гүйцэтгэгч "Юу зэт Эрдэнэ" ХХК-иуд нь Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг огт хэрэгжүүлээгүй нь МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.9-д заасныг зөрчсөн байна.		1	Албан шаардлага	Аймгийн ГХБХБГ-ын дарга	Ч.Отгонжаргал
10	Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болсон Тариат сумын Дасгалын төмөр бетон гүүр, 35 у/м, Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын гүйцэтгэгч "Эвт уул" ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байгаа нь ТБОНХБAYXATX-ийн 46 дугаар 46.1.6 ", МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.6-д 46.1-д заасныг зөрчсөн	5,589.40	1	Албан шаардлага	Аймгийн ГХБХБГ-ын дарга	Ч.Отгонжаргал
11	Жаргалант сумын ОНТХО-аар худалдан авсан гал унтраах тоноглолтой зил 131 машин, худгийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийн урьдчилгаа санхүүжилтийг 50 хувь буюу 32.5 сая төгрөгийг олгосон нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12.4-т заасныг зөрчсөн байна.	32.50	1	Албан шаардлага	Жаргалант сумын Засаг дарга	П.Алтанхуяг
12	Жаргалант сумын ОНТХО-аар хийгдсэн 36.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.30-д заасныг зөрчсөн байна.	36.00	1	Албан шаардлага		
13	Цэнхэр сумын ОНТХО-аар хийгдсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасныг зөрчсөн байна.	29.10	1	Албан шаардлага	Цэнхэр сумын засаг дарга	Д.Галхүү
14	Цэнхэр сумын ОНТХО-аар хийгдсэн 59.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.30-д заасныг зөрчсөн.	59.10	1	Албан шаардлага		
15	Цэцэрлэг сумын ОНТХО-аар хийгдсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.12.4-т заасныг зөрчсөн байна.	20.00	1	Албан шаардлага	Цэцэрлэг сумын засаг дарга	П.Мөнхбат
16	Хашаат сумын ОНТХО-аар хийгдсэн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, Соёлын төв музей тохижилт, уурын зуухны засвар, сумын төвийн худаг засварлах зэрэг 4 төсөл арга хэмжээний 43.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаж орлогод аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2-т Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.31-т заасныг зөрчсөн байна.	43.20	1	Албан шаардлага	Хашаат сумын засаг дарга	Д.Дондов
Албан шаардлагын дүн		7,399.30	11			
Зөвлөмжийн дүн		9,572.03	6			
НИЙТ ДҮН		16,971.33	17			